

## “ЖЭТФИНАНС ББСБ-ЫН” ХХК-ИЙН ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ЭРСДЛИЙН УДИРДЛАГЫН ХОРООНЫ ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмаар Төлөөлөн удирдах зөвлөлийн Эрсдлийн удирдлагын хороо (цаашид “Хороо” гэх)-ны бүрэлдэхүүн, үйл ажиллагааны журам, ТУЗ-ийн үйл ажиллагааны үр дүнг дүгнэх, хорооны гишүүдийг томилох, чөлөөлөх, болон холбогдох бусад харилцааг зохицуулна.
- 1.2 Хороо нь ББСБ-ын гүйцэтгэх удирдлагын зүгээс зээлийн, зах зээлийн, хөрвөх чадварын, үйл ажиллагааны, хууль эрх зүйн, нэр хүндийн болон бусад төрлийн эрсдлийн удирдлагын талаар авч буй арга хэмжээ нь хангалттай байгаа эсэхэд хяналт тавьж дэмжлэг үзүүлэх зорилготой.
- 1.3 Хорооноос чиг үүргийнхээ хүрээнд тодорхой асуудлаар дүгнэлт гаргах, санал, зөвлөмж боловсруулах, шаардлагатай бол Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах үүрэгтэй ба тэдгээр нь зөвхөн зөвлөмж хэлбэрээр байх ба түүнийг ТУЗ заавал биелүүлэх үүрэг хүлээхгүй болно.

### ХОЁР. ХОРООНЫ БҮРЭН ЭРХ, ЧИГ ҮҮРЭГ

- 2.1. Хороо нь дараах асуудлыг эрхлэн хариуцаж, эрхэлсэн асуудлаар ТУЗ-д танилцуулга хийх, санал дэвшүүлэх, шийдвэр гаргуулах байдлаар ажиллана. Үүнд:
  - 2.1.1. ББСБ-ын -ын зээлийн, зах зээлийн, хөрвөх чадварын, үйл ажиллагааны, хууль эрх зүйн, нэр хүндийн болон бусад төрлийн эрсдлийн удирдлагын талаар авч буй арга хэмжээ нь хангалттай байгаа эсэх.
  - 2.1.2. ББСБ-ын -ын эрсдлийн удирдлагатай холбоотой асуудлыг удирдан зохион байгуулах.
  - 2.1.3. ББСБ-ын -ын эрсдлийн удирдлагыг төвлөрсөн хэлбэрээр хэрэгжүүлэх.
  - 2.1.4. ББСБ-ын -ын эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд шаардагдах удирдлагын мэдээллийн системийг бүрдүүлэх.
  - 2.1.5. Зээлийн багцын эрсдлийн удирдлага.
  - 2.1.6. ББСБ-ын -ын үйл ажиллагааны явцад үүсэх заавар, журмаар зохицуулагдаагүй эрсдэлтэй үйл ажиллагаа болон залилан, мэдээллийн нууцлал, техникийн доголдол, програм хангамжийн саатал, бүртгэлийн алдаа, төлбөр тооцооны хяналт, ажиллах хүчний мэдлэг чадвар, тогтвортой байдал зэрэгт эрсдлийн үнэлэлт, дүгнэлт өгөх.
  - 2.1.7. ББСБ-ын -ын үйл ажиллагааны харилцааг зохицуулж буй бодлого, журам, зааврыг эрсдэлгүй байлгах үүднээс жил бүр хянаж холбогдох санал, дүгнэлт, зөвлөмж гаргах.
  - 2.1.8. Санхүүгийн эрсдлийн тайлан шиежилгээ хийх.
  - 2.1.9. ББСБ-ын -ын зорилго, бизнес төлөвлөгөө, ашигт ажиллагаа ба үүсэх эрсдлийн уялдаа холбоо.
  - 2.1.10. Эрсдлийн давтамж тохиолдох хохирлыг тодорхойлж, авах арга хэмжээний талаар зөвлөмж боловсруулах.
  - 2.1.11. Аливаа гэнэтийн хямралын үед хэрэгжүүлэх санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах.
  - 2.1.12. Эрсдлийн удирдлагын зохистой байдлын эргэн хяналт.
  - 2.1.13. ББСБ-ын -ын салбар нэгжүүд өөрсдөө үйл ажиллагаандаа учирч болох эрсдлийг урьдчилан тодорхойлж хэлэлцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, мөн учирсан

талаар баримтлах бодлогыг тодорхойлно.

- 3.6. Хорооны гишүүд дараах эрх, үүрэгтэй:
  - 3.6.1. Хорооны ажил, үйл ажиллагаа, бүх хуралд оролцох;
  - 3.6.2. Салбарын болон зах зээлийн хандлага, мэдээллийн технологи, ББСБ-ын -д үүрэг гүйцэтгэх, стратегийн ач холбогдолтой бусад чиглэлийн хөгжил дэвшилтэй нийцүүлж боловсрох;
  - 3.6.3. Албан ажил гүйцэтгэх явцад олж авсан мэдээллийн нууцыг чандлан хадгалах;
  - 3.6.4. Хорооны шийдвэртэй холбоотой ашиг сонирхлын зөрчил, хараат буй байдалд хяналт тавих;
  - 3.6.5. Хорооны журмын биелүүлэлтийг хянах мөн Хороо, түүний гишүүдийн ажлын гарах өөрчлөлтийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлд мэдэгдэх; талаар жил бүр хяналт, дүгнэлт гаргана.

### **ДӨРӨВ. ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН БА ГИШҮҮДИЙГ СОНГОХ, ЧӨЛӨӨЛӨХ**

- 4.1. Хороо нь 3 гишүүнтэй байх ба гишүүнийг Төлөөлөн удирдах зөвлөлийн олонхын саналаар сонгоно.
- 4.2. Гишүүний бүрэн эрхийн хугацаа нь Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийн хугацаатай адил байна.
- 4.3. Зөвхөн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Хорооны гишүүнээр сонгогдох эрхтэй.
- 4.4. Хорооны гишүүд ББСБ-ын -ын үндсэн удирдлага болон бусад холбогдох ажилтнуудтай харилцан ажиллахад шаардагдах мэдлэг, чадвар, туршлагатай байна.
- 4.5. Төлөөлөн удирдах зөвлөл нь Хорооны гишүүнийг хэзээ ч ажлаас чөлөөлөх эсвэл хорооны бүрэлдэхүүнийг бүхэлд нь шинэчлэх эрхтэй.

### **ТАВ. ХОРООНЫ ХУРЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ**

- 5.1. Хороог ТУЗ-өөс томилсон дарга удирдана.
- 5.2. Хорооны ажил, үйл ажиллагаагаа явуулах үндсэн хэлбэр нь хурал байх бөгөөд Хорооны хурал нь ээлжит ба ээлжит бус байна.
- 5.3. Хорооны хурлыг хорооны үйл ажиллагаа, үндсэн үүргийг цаг тухайд гүйцэтгэхэд шаардагдах тогтмол хугацаанд аль болох ойрхон зайтай хуралдуулна. Ээлжит жилд нэг удаа хуралдуулна. Ээлжит бус хурлыг ББСБ-ын -ын үйл ажиллагаа, шийдвэрлэх асуудлаас хамааран хэдийд ч хуралдуулж болно. Хэрэв Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар Хорооны чиг үүрэгтэй холбоотой асуудал хэлэлцэхээр төлөвлөсөн бол Хороо Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал болох өдрөөс доошгүй хоногийн өмнө хуралдана.
- 5.4. Хурлыг Хорооны дарга, гишүүний санал эсвэл Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн хуралдуулна.
- 5.5. Хурлыг гишүүд биечлэн ирсэн тохиолдолд эсвэл биечлэн ирээгүй гишүүдийн бичгээр үйлдсэн зөвшөөрлийн дагуу мөн видео болон аудио хэлбэрээр явуулж болно.
- 5.6. Хорооны гишүүдийн дийлэнх ирсэн тохиолдолд хурлын ирц бүрдсэнд тооцно.
- 5.7. Хурлын тэмдэглэл бүрт хуралд оролцсон гишүүд гарын үсэг зурна.
- 5.8. Тодорхой асуудлыг хэлэлцэж дууссаны дараа, энэ талаар зөвлөмж, санал, дүгнэлт үйлдэн ТУЗ эсвэл ТУЗ-ийн даргад танилцуулна. Хорооны аль нэг гишүүн олонхоос өөр саналтай байсан бол түүнийг хамтад нь хүргүүлнэ.
- 5.9. Хороо хуралд оролцсон гишүүдийн дийлэнхийн саналаар шийдвэр гаргана.